



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 03 өдөр

Дугаар А/503

Ховд

Тогтоол хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай

“Ахмад настны тухай” хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 221 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сумдын Засаг дарга нарт үүрэг болгох нь:

1. Монголын ахмадын холбоо, түүний салбар нэгжийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг улсын болон тухайн орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх, төрийн болон нутгийн захиргааны зарим чиг үүргийг ахмадын төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж, хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллах

2. Ахмадын өргөө, танхимгүй зарим сумд, өргөө танхим шинээр барих, засварлаж өргөтгөх, үйл ажиллагааны зардлыг 2020 оны төсөвтөө тусгаж, “Ахмад настны тухай” хуулийн 14.5.5 дахь заалтыг ондоо багтааж бүрэн хэрэгжүүлэх арга хэмжээ авах

3. Тогтоолын 5 дугаар заалт “Ахмадын сан” байгуулахыг байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад үүрэг болгосныг бүрэн хэрэгжүүлж “Ахмад настны тухай” хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тавих хяналтыг эрс сайжруулж, хариуцлага тооцож ажиллах

4. Сумдын ахмадын хороодын дарга, тэргүүлэгчид, багуудын ахмадын зөвлөлийн дарга нарт олгох цалин урамшуулалыг 2020 оны төсөвт тусгаж, мөрдөх

5. Ахмадын өдөр, Цагаан сар, бусад тэмдэглэлт өдрүүдэд ахмад настнуудад өгөх бэлэг, дурсгалын зүйлс тэдний дунд зохион байгуулах соёл урлаг, спортын арга хэмжээнд шаардагдах зардлын эх үүсвэрийг ахмадын хороо, зөвлөлийнхөө төсөвт тусган гүйцэтгэлд нь хяналт тавьж бодит ажил болгох

6. Ахмадын өргөө, танхимаа тогтмол үйл ажиллагаа явуулах техник хэрэгсэлтэй болгох чийрэгжүүлэлтийн төхөөрөмжөөр хангах арга хэмжээ авах

7.Захирамжийн биелэлтийг жил бүр тооцон 12 дугаар сарын 25-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст ирүүлэх,


Хоёр.Байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад үүрэг болгох нь:

1.Орон байргүй ахмад настныг түрээсийн орон сууцны хөтөлбөрт хамруулах, хөнгөлттэй нөхцлөөр орон сууц худалдан авах боломжийг бүрдүүлэх, "Ахмад настны тухай хуулийн 12.7 дахь хэсгийн хэрэгжилтийг хангахад "Ахмадын сан" байгуулан ажиллах

Гурав. Захирамжийн биелэлтийг тооцох тухай

1.Захирамжийн биелэлт, үр дүнг сум, байгууллагын ажил дүгнэх үндсэн үзүүлэлтийн нэг болгон тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга /Б.Гомбосүрэн/-д даалгасугай.

2.Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ

